



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханбогд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ӨМА-2022/78/НА-СТА-ТШЗ**

|                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|---------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Даланзадгад хот<br/>2022 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр<br/>Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Хонгорзул<br/>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ж.Болормаа<br/>Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Одончимэг<br/>Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn</p> |
|---------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон 304 тоот  
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn  
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ХАНБОГД СУМЫН 2 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.ТҮВШИНЗАЯА  
ТАНАА

2022.02.15 № 31

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ханбогд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хөрөнгийн үр ашигтай, хэмнэлтэй зарцуулаагүй, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхдээ байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулаагүй, төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Иргэний тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

018020033


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЦЭРЭНБАЯР

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31      | 2021.12.31      |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-----------------|-----------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                 |                 |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 52.60           | 54.00           |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 5,422.00        | 5,268.60        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>5,474.60</b> | <b>5,322.60</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             |                 |                 |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 5,454.60        | 5,322.60        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>5,454.60</b> | <b>5,322.60</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                 |                 |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,195.50        | 1,232.80        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,262.10        | 1,371.90        |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>- 66.60</b>  | <b>- 139.10</b> |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        |                 |                 |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>- 66.60</b>  | <b>- 139.10</b> |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                 |                 |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 5,474.60        | 5,474.60        |
|                                                | Тайлант оны үр дүн                                |                 | - 152.00        |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>5,474.60</b> | <b>5,322.60</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                 |                 |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 1,019.80        | 1,077.20        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 1,017.80        | 1,073.60        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>2.00</b>     | <b>3.60</b>     |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>- 2.00</b>   | <b>- 3.60</b>   |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 |                 |                 |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>-</b>        | <b>0.00</b>     |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -               | -               |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -               | -               |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                 |                 |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>935.30</b>   | <b>971.40</b>   |
|                                                | Урсгал зардал                                     | 935.30          | 971.40          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                 |                 |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>935.20</b>   | <b>971.40</b>   |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           | 741.60          | 787.60          |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | 191.90          | 182.70          |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих   | 1.70            | 1.10            |

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжлийг олон талт оролцоогоор дэмжсэн сурах, сургах үйлийг тасралтгүй чанартай хүргэх эрхэм зорилготойгоор 2020-2021 оны хичээлийн жилд

- Хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлэн, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийг хөгжүүлэх
- Аюулгүй сургууль хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх
- Мэдээлэл харилцаа, технологийн ур чадвараар танхимын болон танхимын бус сургалтын зохион байгуулалтыг эрчимжүүлэх гэсэн зорилтууд тавин ажиллажээ.

## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал болон алслагдсан суманд очиж ажиллах санхүү, хүний нөөц, цаг хугацааны хувьд боломжгүй байсан тул байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, бараа материал, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж байсныг дурдах нь зүйтэй.

## **Дөрөв. Аудитын гол асуудал**

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө батлуулан гал тогооны түрээсийн орлого хүлээн авсан ч заалны орлого төвлөрүүлээгүй, зарим нэг албан байгууллагад төрийн өмчийг үнэ төлбөргүй ашиглуулсан байна.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

### **5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийг хоцруулсан, 2021 оны хагас жилийн тайланг оруулаагүй, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээших 7 ажил гүйлгээний 84.1 сая төгрөгийн худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй байна.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Өмнөговь аймаг Ханбогд сумын сум дундын шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 144/ШШ2021/00040 дугаар шийдвэрийн дагуу тус байгууллагад үйлчлэгчээр ажиллаж байсан Х.Баярмагнайд нэхэмжлэлийн шаардлагын дагуу 841,861 төгрөгийг ажил олгогчоос барагдуулж гэм буруутай этгээдийг тодорхойлж байгууллагад учирсан хохирлыг барагдуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5, 6.4.4, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан

асуудал нь Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй"-д заасантай тус тус нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар багш ажилчдын үр дүнгийн урамшууллыг тус сургуулийн амжилт, багш болон суралцагчдын мэдлэг боловсрол, ур чадварын түвшинд гарсан өөрчлөлттэй уялдуулж шалгах нь зүйтэй.

### Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 148.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.3 сая төгрөгийн алдааг залруулж, 59.4 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 85.0 сая төгрөгийн зөрчилд төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх 3 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 |                         | 1              |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 |                         | <b>1</b>       |       |                            |

### 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн |              | Үүнээс    |            |               |            |                 |             |          |             |
|---|-----------------------------|----------------------|--------------|-----------|------------|---------------|------------|-----------------|-------------|----------|-------------|
|   |                             |                      |              | Залруулга |            | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |             | Зөвлөмж  |             |
|   |                             | Тоо                  | Дүн          | Тоо       | Дүн        | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн         | Тоо      | Дүн         |
| A | 1                           | 2                    | 3            | 4         | 5          | 6             | 7          | 8               | 9           | 10       | 11          |
| 1 | ТШЗ                         | 8                    | 148.7        | 2         | 4.3        | 0.0           | 0.0        | 3               | 59.4        | 3        | 85.0        |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>8</b>             | <b>148.7</b> | <b>2</b>  | <b>4.3</b> | <b>0.0</b>    | <b>0.0</b> | <b>3</b>        | <b>59.4</b> | <b>3</b> | <b>85.0</b> |